



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Дашинчилэн
сумын Орон нутгийн хөгжлийн
сангийн 2023 оны үйл
ажиллагаанд дотоод аудит хийсэн
шалгалтын дүн

Булган аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын
газрын дарга, СХШУАБ

Б.Баттулга

Утас: 99349644 Цахим
хаяг:sankhuu_audit_bu@yahoo.com

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч
С.Бямба-Очир

Утас: 99003286 Цахим
хаяг:sbyambaochir86@gmail.com

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: БУЛГАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ДАШИНЧИЛЭН СУМЫН
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

АУДИТЫН ТӨРӨЛ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ
ХИЙХ

АУДИТЫН ХУГАЦАА : 2025 оны 06 сарын 15-наас 06 сарын 30

Дотоод аудитын нэгжийн дарга :САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАТТУЛГА

Аудитын багийн ахлагч : САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ

С.БЯМБА-ОЧИР

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

2.3 Аудитын арга, аргачлал

2.4 Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

2.5 Аудитын горим, хяналтын сорил

3. Байгууллагын засаглал

3.1 Засаглалын удирдлагын талаар

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

5. ДҮГНЭЛТ

6. ЗӨВЛӨМЖ

2025 оны 06 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар 20-01-02/09

1. ТАНИЛЦУУЛГА

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан баталсан 2025 оны 03 сарын 06-ны өдрийн 1/01 дүгээр удирдамжийн дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

2.1. Аудитын зорилго

Дашинчилэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөмж боловсруулж, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгч, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Дашинчилэн сумын засаг дарга, санхүүгийн ажилтнууд, ОНХС-ийн баримт материалыг хамруулсан. Орон нутгийн хөгжлийн санд 2023 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ. Мөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Хязгаарлалт: Өмнөх оны тус сангаас олгосон хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, орлого бүрдүүлэлтийн ажлын явц, гүйцэтгэлийн баримт материалуудыг хамруулаагүй болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Дотоод аудитаар сумын удирдлага, Санхүү албаны дарга, хөгжлийн бодлогын мэргэжилтэнд дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ыг баримтлан засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авч, аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, баримт материалд дүн шинжилгээ хийж, эдгээрийн үр дүнд хангалттай нотолгоо цуглуулж аудитын дүгнэлтээ боловсруулан гаргасан болно.

Дашинчилэн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дотоод аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн актуудыг эх үүсвэр болгон ашиглалаа. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, эрсдэл ба дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл олж авахын тулд асуулга авах, холбогдох санхүүгийн баримт бичигтэй танилцах;

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны урсгалыг зураглах, эрсдэл ба хяналтыг тодорхойлж, үнэлэх;

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

Дотоод хяналтын сорилын үр дүнд илэрсэн асуудлуудын үндсэн шалтгааны шинжилгээ хийж, удирдлагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;

Дотоод аудитын тайлан бэлтгэж, аудитын хороонд танилцуулан батлуулах, аудитын үр дүнг эргэн хянах

Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, орлого бүрдүүлэлтийн ажлын явц, гүйцэтгэлд сумын ИТХ хяналт, шалгалт хийсэн эсэх, шалгалтаар гарсан үр дүн,

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримт, бараа материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Татварын ерөнхий хууль
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- ✓ Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

2.4. Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2025 оны 06 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дүгээр сарын 13-нд, төлөвлөлтийн үе шатны ажлыг 06 дүгээр сарын 13-наас 06 дүгээр сарын 21-нд, гүйцэтгэлийн шатны ажлыг 06 дүгээр сарын 21-нээс 06 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын дарга, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга хянан удирдаж, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч С.Бямба-Очир төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

2.5. Аудитын горим, хяналтын сорил:

Дотоод аудитаар сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих гэсэн үзүүлэлт дээр мөшгих хяналтын горим, орон нутгийн хөгжлийн сангаас олгосон хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, ажлын явц, гүйцэтгэлийн байдалд шинжилгээний горимыг тус тус хэрэгжүүллээ.

Мөшгих хяналтын горим: Дашинчилэн сумын 2023 оны ОНХСангийн хөрөнгөөр нийт 25 төсөл арга хэмжээнд 396,062.6 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд зураг төсөв, ТЭЗҮ-ийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжүүлсэн ажлыг фото зургаар баримтжуулан гэрээний дагуу ажил хүлээлцсэн акт үйлдсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд сумдын ИТХ хяналтын ажлыг хийгээгүй байна.

Аудитын горимын үр дүн: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод аудит, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг ч тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний гүйцэтгэлд иргэд болон иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавиж ажилаагүй байна.

Шинжилгээний горим: Дашинчилэн сумын 2023 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний санхүүжилт, явцын байдалд шинжилгээний горимыг хэрэгжүүллээ.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.1-т заасны дагуу Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 08 сарын 31-ны өдрийн 15 дугаар хуралдааны 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XV/03 дугаар тогтоолоор төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлогыг 434,965.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 746,798.4 мянган төгрөг, Урьд оны төсвийн үлдэгдэл 241,069.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэгийг 254,676.3 мянган төгрөг нийт 1,760,509.5 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,740,509.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.1. Засаглалын удирдлагын талаар:

Булган аймгийн Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 12 сарын 19-ний өдрийн найм дахь удаагийн сонгуулийн 12 дүгээр хуралдааны XII/08 дугаар тогтоолоор Дашинчилэн сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлогыг 434,965.0 мянган төгрөг, аймгийн

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 663,862.5 мянган төгрөг, Урьд оны төсвийн үлдэгдэл 241,069.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэгийг 254,676.3 мянган төгрөг нийт 1,657,573.6 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,657,573.6 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 344,946.1 мянган төгрөгөөр баталж, ОНХСангийн хөрөнгөөр нийт 25 төрлийн төсөл арга хэмжээнд 344,946.1 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 03 сарын 23-ний өдрийн найм дахь удаагийн сонгуулийн 13 дүгээр хуралдааны XIII/07 дугаар тогтоолоор Дашинчилэн сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлогыг 434,965.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 746,798.4 мянган төгрөг, Урьд оны төсвийн үлдэгдэл 241,069.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэгийг 254,676.3 мянган төгрөг нийт 1,760,509.5 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,760,509.5 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 344,946.1 мянган төгрөгөөр баталсан байна. 2023 оны ОНХСангийн хөрөнгөөр нийт 25 төрлийн төсөл арга хэмжээнд 344,946.1 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 08 сарын 31-ний өдрийн найм дахь удаагийн сонгуулийн 15 дүгээр хуралдааны XV/03 дугаар тогтоолоор Дашинчилэн сумын 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын болон татварын бус орлогыг 459,827.6 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 746,798.4 мянган төгрөг, Урьд оны төсвийн үлдэгдэл 241,069.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэгийг 305,792.8 мянган төгрөг нийт 1,946,533.9 мянган төгрөгөөр баталж, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,946,533.9 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 396,062.6 мянган төгрөгөөр баталсан байна. 2023 оны ОНХСангийн хөрөнгөөр нийт 25 төрлийн төсөл арга хэмжээнд 396,062.6 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн засаглалын төлөвшлийг үнэлэхэд эрсдлийг тодорхойлоогүй, дотоод хяналтын бодлого журамгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэггүй үзүүлэлтүүд эхлэлийн түвшинд байна. Эхлэлийн түвшингээс дараагийн давтамжтай түвшинд хүрэхийн тулд засаглах удирдлагыг эрсдэлийн удирдлагыг тодорхойлоход оролцуулах, дотоод хяналт шалгалтын зохион байгуулах журам баталж, хэрэгжүүлэх, сангийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, баримтаар баталгаажуулах гэсэн арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

3.2. Эрсдэлийн удирдлагын хүрээнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 25 төсөл арга хэмжээнд 396,062.6 мянган төгрөг төлөвсөнөөс хийлгэх төсөл арга хэмжээний ажлын урьдчилгаа төлбөрийг "Халзан дуулга"ХХК-руу 12.333.8 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. энэ гүйлгээний баримтыг шалгахад ажил гүйцэтгэх гэрээ байхгүй байна.

Эрсдэлийн удирдлагын төлөвшлийг үнэлэхэд эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, журам боловсруулаагүй, эрсдлийг бүртгэж, үнэлж, албажуулдаггүй, эрсдлийн үнэлгээ хийдэггүй үзүүлэлтүүд нь ихэнх нь эхлэлийн ба давтамжтай буюу 1,2,3-р түвшинд байна. Дараагийн түвшинд хүрэхийн тулд гүйцэтгэх удирдлага эрсдлийн талаар сургалт зохион байгуулж эрсдэлийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх, эрсдэлийг тодорхойлж бүртгэж, үнэлдэг, албажуулдаг байх, эрсдэлийн удирдлагын дотоод хяналтын системд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох

3.3. Дотоод хяналтын хүрээнд

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл, тайлагналд дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, тус тус хяналт тавихаар зохицуулсан байдаг ч Аймгийн болон сумын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд сумдын ИТХ хяналтын ажлыг хийгээгүй байна.

Дашинчилэн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Тайлант онд хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний гүйцэтгэлд иргэд болон иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавих ажил хийгдээгүй, Дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг үнэлэхэд дотоод хяналт зохион байгуулах журам боловсруулаагүй, албажуулж баримтжуулдаггүй үзүүлэлтүүд нь давтамжтай ба томъёолсон буюу 2-р түвшинд байна.

Үндсэн үйл ажиллагааны талаар

Дашинчилэн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 396,062.6 мянган төгрөгөөр баталсан байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 305,792.8 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 90,269.8 мянган төгрөгөөр зарцуулахаар төсөвлөсөн байна.

Булган аймгийн Дашинчилэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIII хуралдааны 2023 оны 03-р сарын 23-ны өдрийн XIII/07 тогтоол, 2023 оны 08-р сарын 31-ний өдрийн XV хуралдааны XV/03 тоот тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 3 удаа өөрчилсөн байна. Хүснэгтээр сүүлийн байдлаар харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
	1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		396,062.6	396,062.6
1.1	Дэд хөтөлбөр	2023	6,000.0	6,000.0
1.2	Улсын баяр наадам	2023	10,000.0	10,000.0
1.3	Гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгт	2023	19,500.0	19,500.0
1.4	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт	2023	18,896.4	18,896.4
1.5	Зураг төсөв хийлгэх	2023	33,000.0	33,000.0
1.6	Хараат багийн төвийн барилга	2023	19,000.0	19,000.0

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

1.7	Хараат багийн төвийг хашаажуулах	2023	8,000.0	8,000.0
1.8	Задгай худалдаа үйлчилгээний цэг барих	2023	5,000.0	5,000.0
1.9	Жишиг гудамж байгуулах	2023	15,000.0	15,000.0
1.10	Зам засвар арчилгаа, тохижолт	2023	5,000.0	5,000.0
1.11	Сумын төвийн дэд бүтцийг сайжруулах	2023	19,000.0	19,000.0
1.12	Айл өрхийн нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбох	2023	19,000.0	19,000.0
1.13	Цагдаагийн техник тоног төхөөрөмж шинэчлэх	2023	1,000.0	1,000.0
1.14	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	2023	10,000.0	10,000.0
1.15	Хог хаягдлын менежментийг сайжруулах/түүхий эд преслэгч, хог ангилахсав/	2023	15,000.0	15,000.0
1.16	Орон нутаг судлах танхимыг засварлах, тохижуулах	2023	8,000.0	8,000.0
1.17	Хийморийн толгой, сумын төвийн баруун, зүүн өндөрлөгийг засварлах, тохижуулах	2023	19,000.0	19,000.0
1.18	Албан байгууллагуудыг камержуулах	2023	6,500.0	6,500.0
1.19	Төрийн өмчийн автомашины грашийг засварлах, халаалтад холбох	2023	19,500.0	19,500.0
1.20	Наадмын талбайн зураг төсөв хийлгэх	2023	26,000.0	26,000.0
1.21	Цагдаагийн хэсэгт автомашин авах	2023	16,500.0	16,500.0
1.22	Нутаг дэвсгэрийн зураг хийлгэх	2023	7,529.7	7,529.7
1.23	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийн үлдэгдэл	2022-2023	8,520.0	8,520.0
1.24	Нийтийн эзэмшлийн гудамж талбай тохижуулах/4-н замын уулзварт/	2023	20,000.0	20,000.0
1.25	Төрийн өмчийн барилга байгууламжийн засвар	2023	61,116.5	61,116.5

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

2. Сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүн		396,062.6	396,062.6
1	Сум орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг дүн	2023	305,792.8
2	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	2023	90,269.8

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийт 25 төсөл арга хэмжээг 396,062.6 мянган төгрөгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэхээс 20 нь бүрэн хэрэгжиж, 2 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад нэг ч иргэн, аж ахуй нэгж оролцоогүй тул хэрэгжээгүй, 2 нь 2022 онд эхэлсэн ажил 2023 онд ажлын гүйцэтгэл хийгээгүй тул үлдэгдэл төлбөрийг шилжүүлээгүй, 1 төсөл арга хэмжээнд гэрээ хийгээгүй гүйлгээ хийсэн байна.

2023 оны төсөл арга хэмжээнд хэрэгжүүлж, ажилласан байдал:

1.1 Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Дэд хөтөлбөрийн ажлын хүрээнд нийт **3,712.0 мянган төгрөгийг** зарцуулсан байна. Үүнд:

- Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/18 тоот захирамжаар “Өвлийн өнгө – Мөсний баяр 2023” арга хэмжээний зардалд 510.0 мянган төгрөг,
- 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/50 тоот захирамжаар Урд бүсийн волейболын аварга шалгаруулах тэмцээний шатахууны зардалд 125.0 мянган төгрөг,
- 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/60 тоот захирамжаар “Шинэ хөгжлийг түүчээлэгч шилдэг төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-д 30 малчин эмэгтэй оролцуулах зардалд 665.0 мянган төгрөг,
- 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/65 тоот захирамжаар “Тариаланчдын зөвлөгөөн 2023” арга хэмжээнд 5 тариаланч оролцуулах шатахууны зардалд 175.0 мянган төгрөг,
- 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/88 тоот захирамжаар софт волейбол, сагсан бөмбөгийн тэмцээнд 580.0 мянган төгрөг,
- 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/108 тоот захирамжаар тусгай хэрэгцээт болон бүтэн өнчин хүүхдүүдийн гэрийн эргэлт, үзлэг зохион байгуулах арга хэмжээнд 262.5 мянган төгрөг,
- 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/172 тоот захирамжаар 9–12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Дэвжээ” тэмцээнд 120.0 мянган төгрөг,
- 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/205 тоот захирамжаар сумын ЕБС-ийн сурагчдын эцэг эхийн зөвлөгөөнд 172.0 мянган төгрөг,
- 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/212 тоот захирамжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах аяны хүрээнд зохион байгуулсан тэмцээний зардалд 520.0 мянган төгрөг,
- 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/231 тоот захирамжаар хүүхдийг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх шатахууны зардалд 100.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

1.2 Сумын баяр наадамд зориулсан зардалд:

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

2023 оны 06-р сарын 23-ний өдрөөр А/129 тоот захирамжаар Сумын баяр наадмыг зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөгийг ОНХС-аас зарцуулсан байна. хавсралт

№	бүтээгдэхүүн	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Айраг	640л	5,000	3,200,000
2	Сандал	100 ш	30,000	3,000,000
3	Салют	1 ш	660,000	660,000
4	Шатахуун	437.36 л	2,500	1,93,400
5	Бүжгийн хувцас	5 ш	20,000	100,000
6	Өргөмжлөл	66 ш	29,500	1,946,600
	нийт			10,000,000

1.3 Булган аймгийн дашинчилэн сумын 4-р багийн "гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх, засвар арчилгаа хийх" ажлын гэрээг 2023 оны 05-р сарын 12-ний өдрөөр 2023/01 тоот гэрээг ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, гүйцэтгэгчийг төлөөлж Ц.Баясгалан нар 19,500.0 мянган төгрөгөөр байгуулсан байна.

1.4 "Мод тарих суулгац нийлүүлэх, хашаа барих" 8,500.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 06-р сарын 05-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Хөвөнтэй ой ХХК-ийн захирал Ч.Оюун нар байгуулсан байна. Мод тарих суулгац нийлүүлэх, хашаа барих ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 10-р сарын 18-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Б.Хандсүрэн нар байгуулсан байна.

1.5 Зураг төсөв хийлгэх ажлын хүрээнд 2022 оны 12-р сарын 27-ны өдөр 11-1/22 дугаартай гэрээг Ганжим ХХК-тай хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 81 га талбайд 1:500 масштабтай байр зүйн зураглал, Цогт хун тайжийн талбайн тохижолтын ажлын зураг төсөлийн ажлыг 11,939.4 мянган төгрөгийн гэрээ байгуулж төлбөрийг 2023 оны 02-р сарын 17-нд шилжүүлсэн байна.

1.6 "Хараат багийн төвийн барилга барих" 19,000.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 04-р сарын 12-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Ч.Ганхуяг нар байгуулж, 2023 оны 04-р сарын 21-нд 80 хувь нь 15,200.0 мянган төгрөг, 2023 оны 07-р сарын 21-нд 20 хувь нь 3,800.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

1.7 Булган аймгийн Дашинчилэн сумын "Хараат багийн төвийг хашаажуулах" 8,000.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 04-р сарын 12-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Э.Одгэрэл нар байгуулж, 2023 оны 04-р сарын 21-нд 80 хувь нь 6,400.0 мянган төгрөг, 2023 оны 07-р сарын 21-нд 20 хувь нь 1,600.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

1.8 Булган аймгийн Дашинчилэн сумын "Зөөврийн сууц нийлүүлэх" 2023/06 тоот гэрээг 4,590.0 мянган төгрөгийн гэрээг 2023 оны 04-р сарын 12-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Нямдулам нар байгуулж, 2023 оны 06-р сарын 27-нд 4,590.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

1.9 Жишиг гудамж байгуулах төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтад нэг ч иргэн, ах ахуй нгэж оролцоогүй тул Хэрэгжээгүй

1.10 Булган аймгийн Дашинчилэн сумын "ажил гүйцэтгэх" 12 тоот 1,000.0 мянган төгрөгийн гэрээг 2023 оны 10-р сарын 26-ны өдөр Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, Б.Цамба нар байгуулж, 2023 оны 10-р сарын 26-нд 1,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 11-р сарын 07-ний өдрийн А/200 тоот захирамжаар "Зам түрэх" 700.0 мянган төгрөгийн зардлыг ОНХС-гаас 2023 оны 11-р сарын 07-нд 700.0 мянган төгрөгийг Хаан банкны 5031334577 тоот дансанд шилжүүлсэн байна.

1.11 “Булган аймгийн харьяа аврах бүлгийн байрны засвар”-ын гэрээг 2023 оны 09-р сарын 20-ны өдөр 19,000.0 мянган төгрөгийн Дашинчилэн сумын ЗДТГ-ын дарга Ц.Болорцэцэг, иргэн Ц.Пүрвээ нар байгуулсан байна. 2023 оны 09-р сарын 22-нд Ц.Пүрвээгийн 5005882297 тоот дансруу шилжүүлсэн байна.

1.12 Айл өрхийн нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системд холбох төсөл арга хэмжээний шалгаруулалтад ямар ч иргэн, ААН оролцоогүй тул хэрэгжээгүй

1.13 Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 10-р сарын 26-ний өдрөөр А/189 тоот захирамжаар Цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд 793.5 мянган төгрөгөөр “Пи си молл”ХХК-аас 3-н үйлдэлд принтер дагалдах зүйлсийг авч хүлээлгэн өгсөн байна.

1.14 Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 06-р сарын 06-ний өдрөөр А/118 тоот захирамжаар Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад 3,039.7 мянган төгрөгөөр мэргэжлийн ангийн хувцас 59 ширхэг нэг бүрийг нь 49.5 мянган төгрөг нийт хувцасны үнэ 2,920.5 мянган төгрөг, тэмдэглэгээний хэвлэлийн зардалд 97.2 мянган төгрөгөөр тус тус зарцуулсан байна.

1.15 Хэрэгжээгүй, сонгон шалгаруулалтад иргэн, аж ахуй нэгж оролцоогүй

1.16 Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 03-р сарын 31-ний өдрөөр А/52 тоот захирамжаар Сумын соёлын төвийн орон нутаг судлах танхимыг засварлах, тохижуулахад 8,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

1.17 Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг даргын 2023 оны 03-р сарын 02-ний өдрөөр А/20 тоот захирамжаар хийморийн толгой, сумын төвийн баруун, зүүн өндөрлөг тохижуулах зардлаас эх бэлтгэлд “Хеброн”ХХК-руу 100.0 мянган төгрөг, геодизи, газар зүйн хэмжилт хийлгэхэд “Аркжис инженеринг”ХХК-руу 728.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

1.18 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны камерыг “БЭСТ КОМПЬЮТЕРС ТЕХНОЛОГИ”ХХК-аас 4 камер 799.6 мянган төгрөгөөр худалдан авч суурилуулсан байна.

1.19 Ууган төмөрт ХХК-руу 18,500.0 мянган төгрөгийг шилжүүлж ажилласан байна.

1.20 Хэрэгжээгүй Наадмын талбайн зураг төсөв хийлгэх төсөл арга хэмжээний ажлын урьдчлгаа төлбөрийг “Халзан дуулга”ХХК-руу 12.333.8 мянган төгрөгийг шилжүүлсэн. Баримтыг шалгахад ажил гүйцэтгэх гэрээ байхгүй байна.

1.21 Цагдаагийн хэсэгт автомашин авах ажлын хүрээнд иргэн Ч.Цэвэлмаатай гэрээг байгуулан toyota axio автомашиныг 16,500.0 мянган төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өгсөн байна.

1.22 Дэвсгэр зурагын ажил хийгдээгүй учир үлдэгдэлийг шилжүүлээгүй

1.23 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй тул үлдэгдэлийг шилжүүлээгүй

1.24 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижолтын ажлыг иргэн Ч.Ганхуягтай гэрээг байгуулан 19,000.0 мянган төгрөг шилжүүлж 1070 метр хашааг худалдан авсан байна.

1.25 Төрийн өмчийн барилга байгууламжийн засварын ажлын хүрээнд ЗДТГ-н эзэмшилд байдаг төрийн албан хаагчдын орон сууцыг засварлах, хүүхэд хөгжлийн төвийг засварлах, тохижуулах ажилд Говь хангай-3,982.0 мянган төгрөг, Хашхан-2,849.5 мянган төгрөг, Б.Хандсүрэн-3,168.5 мянган төгрөгийг тус бүр шилжүүлж, нийт 10,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

2023 онд хийгдэх төсөл, арга хэмжээ

Нийт 8 төсөл арга хэмжээнээс 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1.3 хилийн цэс тогтоох ажил:

Дашинчилэн сумын Засаг дарга Д.Луттөмөр, Сод сүрвей ХХК-ний захирал С.Цогжаргал нар 2023 оны 06 сарын 05-ний өдөр "Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт байрлах тариалангийн талбайн 34 нэгж талбарт хяналтын хэмжилт, зураглал хийх ажлын гэрээ"-г 9,604.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, гэрээний дагуу төлбөрийг 100 хувь 2023 оны 07-р сарын 17-ны өдөр малын тоо толгойн албан татварын орлогоос шилжүүлсэн байна.

1.5 өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх:

Дашинчилэн сумын засаг даргын 2023 оны 02-р сарын 09-ний өдрийн А/26 тоот захирамжаар малын тоо толгойн албан татвараас орсон орлогоор сумын аюулгүйн нөөцөд "Од групп"-ээс 23 тн хивэг худалдан авахад 14,950.0 мянган төгрөгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардлаас зарцуулсан байна. малын тоо толгойн албан татварын орлого төлөвлөсөнөөр ороогүйгээс төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

Засаглалын удирдлагын хүрээнд:

Илэрсэн асуудал 1	ажил гүйцэтгэх гэрээгүй урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: 2023 оны 02-р сарын 06-ны өдөр Бу.Дашинчилэн ОНХСангийн 100040552400 тоот данснаас "Халзан дуулга" ХХК-руу гэрээ хийгдээгүй байхад урьдчилгаа 12,333.8 мянган төгрөгийг "Наадмын талбайн зураг төсвийн урьдчилгаа Дашинчилэн ЗДТГ" гэсэн гүйлгээний утгатай шилжүүлсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур: Гэрээ хийж гэрээг үндэслэж гүйлгээ хийх, 100 хувь буюу ажлыг хүлээлгэн өгсөнөөр төлбөрийг нэхэмжлэлийн дагуу 100 хувь төлж дуусгахаар заасны дагуу санхүүжилтийг олгох ёстой	
Асуудлын үндсэн шалтгаан: Гэрээ хийгдээгүй байхад урьдчилгаа төлбөр 12,333.8 мянган төгрөгийг Халзан дуулга ХХК-руу 2 сарын 6-ны өдөр шилжүүлсэн.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, ажил удаашрах сөрөг үр дагавартай	
Зөвлөмж: төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг уншиж судлах;	

Дотоод хяналтын хүрээнд:

Илэрсэн асуудал 2	Дашинчилэн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

Бодит байдал: сумын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд сумын ИТХ хяналтын ажлыг хийгээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Асуудлын үндсэн шалтгаан: ОНХС-ийн зарцуулалтын хяналтад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хангалтгүй, зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт байхгүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: ОНХС-ийн зарцуулалтад хяналтыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо бага байгаагаас шалтгаалан санхүүжилт үр дүн муутай зарцуулагдах, сангийн үйл ажиллагааг хохироох эрсдэл үүснэ.

Зөвлөмж: Аймгийн болон сумын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд сумын ИТХ хяналтын ажлаа хийж хэвших;

5. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Тус сумын ОНХС нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангаж, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж ажилласан байна.

ОНХС-ийн зарцуулалтад иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллахгүй байна. Энэ нь иргэд олон нийтэд хууль, тогтоомж, журмын мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар сурталчилдаггүй, мэддэггүйтэй холбоотой бөгөөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх, хууль, журмыг сурталчлах шаардлагатай байна.

ОНХС-ийн зарцуулалтын хяналтад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо хангалтгүй, зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хяналт сул байна.

Дашинчилэн сумын ОНХС-гийн хөрөнгөөр Наадмын талбайн зураг төсөв хийлгэх төсөл арга хэмжээнд "Халзан дуулга"ХХК-тай гэрээ хийгээгүй байтал урьдчилгаа 2023 оны 02-р сарын 06-нд 12,333.8 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлийг журмын дагуу тайлагнаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн ч цахим хуудсанд ил тод мэдээллэх байдал хангалтгүй байна.

6. ЗӨВЛӨМЖ:

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ :АБ4000

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг дагуу зохион байгуулж ажиллах

2. ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийн талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулах, мэдээллийн дагуу санхүүжилтийг олгож хэвшүүлэх;

3. сумын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын явц, гүйцэтгэлд сумын ИТХ хяналтын ажлаа хийж хэвших

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан 2025 оны 10 дугаар сарын 23-ны дотор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр болон sankhuu_audit_bu@yahoo.com хаягаар хариу ирүүлэх.


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ  Б.БАТТУЛГА

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ  С.БЯМБА-ОЧИР

ТАНИЛЦСАН:

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
 С.МЭНД-АМАР

ДАШИНЧИЛЭН СУМЫН САНХҮҮ
АЛБАНЫ ДАРГА Б.ХОНГОРЗУЛ